



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/63

Арвайхээр

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд
зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын онцгой комиссын даргын 2021 оны 651 дүгээр албан бичгийн дагуу Улаанбаатар хот болон бусад аймаг орон нутгаас ирэх Өвөрхангай аймгийн харьяалалтай иргэдийг түргэвчилсэн оношлуураар шинжилгээнд хамруулж, татан авах ажлыг 2021 оны 02 дугаар сарын 06-ны өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 09-ны хооронд зохион байгуулж, халдварт хамгааллын дэглэмийг сахиулж, гэрийн тусгаарлалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Өвөрхангай аймаг дахь “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ний газрын дарга (М.Жамъяншаав), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Улаанбаатар хот болон голомттой бүсээс ирж гэрийн тусгаарлалтад орох иргэдийн гар утсанд цахим хяналтын (TRACKER gps) программыг суулгаж, идэвхжүүлэн, мэдээлэл дамжуулах, хяналт тавих ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ний газрын дарга (М.Жамъяншаав)-д даалгасугай.

3. Аймгийн хэмжээнд Коронавируст халдварт (Ковид-19) цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 18.00 цагаас 02 дугаар сарын 20-ны өглөөний 06.00 цаг хүртэл аймаг, сум хоорондын орох, гарах автотээврийн хэрэгсэл, иргэдийн зорчих хөдөлгөөнийг хязгаарлаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Аймаг, сумын төв доторх иргэдийн зорчих хөдөлгөөнийг 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 06.00 цагаас нээж, төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын ажиллах цагийн хуваарийг хэвийн горимд шилжүүлсүгэй.

011100140

2.

5.Дээрх хязгаарлалт тогтоосон хугацаанд хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг хавсралтаар батласугай.

6.Коронавируст халдвар (Ковид-19) цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор авсан арга хэмжээ, заавар зөвлөмжийг иргэд, олон нийтэд шуурхай мэдээлж ажиллахыг аймгийн Шуурхай штаб (дэд хурандаа Б.Батбилэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

Аймгийн Засаг даргын 2021 оны *08*
дугаар сарын *05*-ны өдрийн *11/63* дүгээр
захирамжийн хавсралт

ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХГҮЙ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА,
АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

| | |
|-----|--|
| 1. | Эрчим хүчээр хангах үйл ажиллагаа |
| 2. | Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа |
| 3. | Шатахуун, түлшний хангамж, түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа |
| 4. | Төв, суурин газрын дулаан, ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын үйл ажиллагаа |
| 5. | Эрүүл мэндийн байгууллага, эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн үйл ажиллагаа |
| 6. | Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаа |
| 7. | Шүүх, прокурор, |
| 8. | Оршуулгын үйл ажиллагаа |
| 9. | Малын өвс, тэжээлийн үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлтийн үйл ажиллагаа |
| 10. | Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллагын үйл ажиллагаа |

-оOo-